

ДЭЭД БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	АГГ-2022/21-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Аудитын нэр:	Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор Б.Болормаа, Б.Эрдэнэбат, Аудитор С.Одонцэцэг, Г.Жавхлан, Ш.Наранбаатар, Ц.Цолмон, Ж.Оюунтуяа,

Хоёр. Аудитын үр дүн:

Аудитын зорилт: “Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг доорх 2 дэд зорилтын хүрээнд гүйцэтгэн дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Үүнд:

- Боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод нийцүүлэн дээд боловсрол олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх;
- Дээд боловсролын сургалтын байгууллагын стандарт, сургалт, судалгааны үйл ажиллагаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ: Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Боловсролын зээлийн сан, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон зарим төрийн өмчийн, төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн үйл ажиллагааг хамрууллаа.

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Тогтвортой хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэл, нийгмийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахуйц дээд боловсролын хууль, эрх зүйн шинэчлэл хийгээгүй байна

УИХ-аас 1995 онд боловсролын багц хуулийг баталж, боловсролын шинэ тогтолцоонд шилжсэнээр хувийн өмч дээр суурилсан бүх шатны боловсролын байгууллагыг байгуулах, суралцагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн нэг эх үүсвэр нь сургалтын төлбөр байх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэх боломж бүрдэж, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан хууль, эрх зүйн шинэчлэлийг хийсэн байна. Үүнд:

- 2002 онд Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль;
- 2009 онд Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль;
- 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль;
- 2018 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль.

Боловсролын тухай хуульд 2002 оноос хойш 31, Дээд боловсролын тухай хуульд 11, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт Нийгмийн тогтвортой хөгжил хэсгийн 2.2.3 дахь “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилтын 4-т “Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно” гэсэн зорилтыг дэвшүүлэн дараах 3 үе шатаар хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- I үе шат (2016-2020 он):** Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх;
- II үе шат (2021-2025):** Хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу шинжлэх ухаан, технологийн кластер, парк байгуулж, үндэсний дөрвөөс доошгүй их сургууль Азийн шилдэг их сургуулийн эгнээнд орсон байх;
- III үе шат (2026-2030):** Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байх.

Дэлхийн олон улс орон өндөр технологийг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хөгжлийн бодлогыг чиглүүлдэг бөгөөд инновацын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэхэд их сургуулиуд ялангуяа, судалгаанд суурилсан их сургуулиуд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг байна.

Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого” -ын 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх” гэсэн арга арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.18-д “...судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасны дагуу олон улсын түвшинд нийцсэн инновацыг бий болгох, нэвтрүүлэх чадамжийг бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх зорилгоор “Судалгаанд суурилсан их сургуулийн хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор баталсан байна.

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын чиглэлээр дараах 4 үндсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- 1) Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлэх;
- 2) Их, дээд сургууль, коллежийн оюутны суралцах эрхийн баталгааг хангаж, өрхийн боловсролын зардлыг бууруулж, дээд боловсролын сургалтын чанарыг дэмжинэ. Оюутанд үндэсний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Оюутан сургалтын төлбөрийн дарамтгүй, эрүүл мэндийн үйлчилгээтэй, суралцах хугацаандаа цагийн ажил эрхлэх, дотуур байранд амьдрах боломжтой болгох;
- 3) Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх;
- 4) Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгох.

Дээрх зорилтын хүрээнд дээд боловсролын чиглэлээр 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 7 ажлын хэрэгжилт удаашралтай байна. Тухайлбал:

- Дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх ажил;
- Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- “Боловсролын зээлийн сан”-ийн санхүүжилтээр гадаадад суралцагчдад зээл олгох, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох;
- Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад элсэгчдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулж, суралцагчдын тоог 2 дахин нэмэгдүүлэх;
- Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлэх;
- Нээлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх зэрэг арга хэмжээ.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд дээд боловсролтой холбоотой дараах 8 арга хэмжээг тусгасан боловч хэрэгжилт нь эхлэл төдий байна. Үүнд:

- Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлэх;
- Орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээний хүрээнд “Их, дээд сургуулийг Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоол гарч, төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн боловч санхүүгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлээгүй;
- Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршидаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх;
- Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон шинэ бүтэц зохион байгуулалтад орсон боловч дээд боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны судалгааны ажлуудыг хийж эхлээгүй;
- ДБСБ-ын судалгааны болон бусад зардалд төрөөс үзүүлэх дэмжлэг дутмаг;
- Орон нутгийн их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулахад шаардлагатай санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй;
- Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд тусгасан арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь холбогдох төсөл арга хэмжээний төлөвлөлт бодит бус, хууль эрх зүйн орчин бүрдээгүй, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүйтэй холбоотой байна.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд дээд боловсролтой холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан боловч санхүүжилтийн асуудлаас шалтгаалан зарим ажлууд эхлэл төдий хэрэгжиж байна. Үүнд:

- Төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгож, эрх зүйн орчныг сайжруулан судалгааны их сургууль болгох;
- хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгох;
- Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, хөдөлмөрийн зах зээлийн захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулах;
- багийн мэргэжлийн үр чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангах;
- цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн тогтолцоог бэхжүүлэх;
- олон улсад өрсөлдөх чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх ажлын хүрээнд “Дээд боловсролд хамаарах эрмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ийг УИХ-аар соёрхон батлах асуудлыг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан байна.

Салбарын яамнаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй нь төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлээгүй, удирдлагын тогтворгүй байдал зэргээс шалтгаалжээ.

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар баталжээ.

Тус бодлогын баримт бичигт дээд боловсролыг хөгжүүлэх чиглэлээр 3 үндсэн зорилт, 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Суралцагчийн хэрэгцээ, шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулах (16);
- Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх(10);
- Дээд боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох (5).

БШУЯ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хууль, журамд заасан хугацаанд тайлагнасан байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын засаглал, удирдлагын тогтолцооны бие даасан, хараат бус байдлыг хангаагүй байна

Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоолоор баталж, дээд болон мэргэжлийн боловсролын асуудлыг хариуцах газруудын үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн байна.

Дээрх үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт дараах тэргүүлэх чиглэлийг тусгасан байна.

- Мэргэжлийн болон дээд боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;
- Боловсрол, шинжлэх ухааны салбарын сайн засаглалыг бэхжүүлэх, салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгоход эрх зүйн дэмжлэг үзүүлэх;
- Боловсрол, шинжлэх ухааны салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлж, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг шинэчлэх;
- Боловсрол, шинжлэх ухааны салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах.

Дээд боловсролын салбарын үйл ажиллагаанд оролцож буй байгууллага, газрын чиг үүрэг давхардалгүй боловч Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн Боловсролын үнэлгээний төв нь хууль, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Энэ нь дээрх газруудын санхүүгийн болон хүний нөөцийг бодитой төлөвлөж, батлаагүй, хэрэгжүүлэх чиг үүрэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусгагдаагүйтэй холбоотой байна.

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Их сургууль, дээд сургууль, коллежийн удирдах зөвлөл нь Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12-т заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу төрийн өмчийн их, дээд сургуулийн удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

- Боловсролын байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дүрмийг батлах, өөрчлөх;
- Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох;
- Хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох;
- Сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох;
- Сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж үүсгэн байгуулагчид өгөх;
- Удирдах зөвлөл нь захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн их, дээд сургуулийн захирлыг томилох бүрэн эрхтэй боловч төрийн өмчийн зарим их сургуулийн захирлыг сонгон шалгаруулалтгүйгээр томилсон байна.

Их, дээд сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр 1-7 жил буюу дунджаар 1.9 жил ажилласан нь дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагын тогтворгүй байдлыг бий болгож, тэдгээрийн бие даасан байдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын чанар зохих шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэх ажил дутмаг байна. Тухайлбал:

- Боловсролын үнэлгээний төв нь 2019 онд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн дээд боловсролын шинэчлэл төслийн санхүүжилтээр эрх зүй, бизнесийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 53 их, дээд сургууль, коллежийн 21,424 оюутныг хамруулан бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурь болон мэргэжлийн чиглэлд заавал судлах зарим хичээлтэй харьцуулсан судалгааг хийснээс өөр дээд боловсролын салбарт 2019-2022 онд чанарын үнэлгээ хийгээгүй;
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь эрх бүхий хөндлөнгийн шинжээчдээр дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын үйл ажиллагааны чанарыг баталгаажуулалт хийдэг бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 88 их, дээр сургуулиас 67, нийт 3434 сургалтын хөтөлбөрийн 489-ийг магадлан итгэмжилсэн;
- Боловсрол, шинжлэх ухааны яам тодорхой шалгуур, шаардлагыг хангасан их, дээд сургуульд тусгай зөвшөөрлийг олгож, сургалтын үйл ажиллагааг 5 жил тутамд аттестатчилсан боловч ихэнх сургуулийн багшлах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар зохих түвшнээс доогуур, сургалтын хэрэгсэлдэхүүн, лаборатори тоног төхөөрөмж хангалтгүй, сургалтын байгууллагын дотоод хяналтын тогтолцоо төлөвшөөгүй байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал олон улсын чиг хандлагад нийцээгүй байна

Дээд боловсролын тогтолцоог их сургууль, дээд сургууль, коллеж гэж ангилсан боловч судалгааны их сургууль гэсэн онцгой ангиллыг хуульчлаагүй байна.

Боловсролын тухай хуулийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Стандартыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэсэн заалтыг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болгосноос шалтгаалан Боловсрол, шинжлэх ухааны яам тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4-т заасан бүх шатны боловсролын стандарт, норм, нормативыг боловсруулаагүй байна.

Олон улсын туршлагаас харахад дээд боловсролын хөгжлийн гол хүчин зүйл нь судалгааны их сургууль байдаг бөгөөд нарийн мэргэжлээр дагнасан цөөн тооны их сургуультай, дээд боловсролын системийг тодорхой ангиллаар хувааж хөгжүүлэн судалгааны их сургуулийг бий болгох нь ач холбогдолтой гэж үздэг байна.

Цаашид олон улсын жишигт нийцсэн судалгаанд суурилсан их сургуульд тавих шаардлага, шалгуурыг тогтоох, судалгааны ажлын үр дүнг үнэлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх, чадварлаг судлаачдыг төвлөрүүлэх, судалгаа боловсруулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэх арга замыг тодорхой болгох шаардлагатай байгаа бөгөөд дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулах хууль, эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй байна.

Их дээд сургуулиудыг хотхоноор хөгжүүлэхээр төлөвлөсөн боловч санхүүжилтийн эх үүсвэргүйгээс хэрэгжилт хангалтгүй байна

Засгийн газрын 2015 оны 133, 2021 оны 321, 367 дугаар тогтоолыг үндэслэн их сургуулиудыг бүсчлэн хотхоноор хөгжүүлэх, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах бодлогыг баримтлан дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

- Багануур дүүрэгт шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийн цогцолборыг байгуулахаар хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийгдэж, магадлалын дүгнэлт гарсан боловч хэрэгжээгүй;
- Орхон аймагт уул уурхай, технологийн чиглэлээр ШУТИС-ийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг байгуулахаар инженер-геологийн судалгааг хийж, ерөнхий төлөвлөгөөг баталсан боловч хэрэгжээгүй;
- Дархан-Уул аймагт хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг байгуулахаар газрын асуудал нь шийдвэрлэгдсэн боловч хэрэгжээгүй;
- Дорнод аймагт Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төвийг байгуулахаар газрын асуудал нь шийдвэрлэгдэж, барилгын ТЭЗҮ болон зураг төсөө нь батлагдаж, гүйцэтгэгч нь шалгарч, зохих ажлыг гүйцэтгэж эхэлсэн боловч 2022 онд санхүүжилтгүйгээс зогссон;
- Ховд аймагт Баруун бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төвийг байгуулахаар газрын асуудал нь шийдвэрлэгдэж, урьдчилсан судалгаа нь хийгдсэн боловч хэрэгжээгүй байна.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг орон нутагт “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” хэлбэрээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор дараах төрийн өмчийн дээд сургууль, коллежийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь 2022-2023 оны хичээлийн жилээс эхлүүлэхээр шийдвэрлэжээ. Тухайлбал:

- Өмнөговь аймагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн дээд сургууль;
- Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа “Эрдэнэт политехник коллеж”;
- Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн харьяанд Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв;
- Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн харьяанд Цэргийн хөгжмийн политехник коллеж;
- Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяанд Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв зэрэг болно.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 2.1.4-т орон нутаг дахь их, дээд сургуулиудыг “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-оор хөгжүүлэхээр төлөвлөж, Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор Хөшигийн хөндийд дижитал их сургуулийн сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлсэн хэв шинжтэй дээд боловсролын сургалтын байгууллагыг шинээр байгуулахаар шийдвэрлэж, сургалт-үйлдвэрлэлийн цогцолборыг нийт 500 га газарт байгуулах ерөнхий төлөвлөгөө боловсруулах сонгон шалгаруулалтын ажил хийгдэж, 2023 оны 1 дүгээр сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн байна.

Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой уялдуулан сургалтын арга зүйн шинэчлэл, багшлах боловсон хүчнийг чадавхжуулах, сургалтын орчин, өрсөлдөх чадварыг сайжруулах, суралцагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2012-2022 онд дээд боловсролын салбарын хэмжээнд хандивлагч орон, олон улсын байгууллагаас нийт 12 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

- Олон улсын түвшинд магадлан итгэмжлэл хийх, өөрийн шинжээчдийг гадаад, дотоодын их дээд сургуульд ажиллуулах, сургалт зохион байгуулах, мэргэжилтэн солилцох үйл ажиллагааг өргөжүүлсэн;
- Их, дээд сургуулийн сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн лабораторид хийж буй судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн тоо 2020 онд 2016 оноос 2.4 дахин, тэргүүлэх салбарын судалгааны тоо 2 дахин, салбар дундын судалгааны тоо 11 дахин өссөн;
- Орон нутгийн их, дээд сургуулийн номын сан, сургалтын лаборатори, зайны сургалтын төвд тоног төхөөрөмж, программ хангамж, багаж хэрэгсэл, тавилга нийлүүлж, Говь-Алтай аймаг дахь АШҮҮИС-ийн салбар сургуулийн Иммунологи, молекул биологийн лаборатори, Дорнод их сургуулийн Газрын тос судлалын лаборатори, ХААИС, Дархан-Уул аймаг дахь Агроэкологи Бизнесийн сургуулийн практик дадлагын орчныг бий болгосон;
- ЮНЕСКО-оос гаргасан “Боловсролын олон улсын стандарт ангилал”-ын “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-д дээд боловсролын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг тус тус тодорхойлж, шинэчлэн боловсруулсан байна.

БҮЛЭГ 2. ДЭЭД БОЛОВСРОЛ ОЛГОЖ БҮЙ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭГ БҮРЭН ХАНГАХГҮЙ БАЙНА

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хянадаггүйгээс зарим сургалтын хөтөлбөрүүд нийтлэг шаардлагад нийцээгүй байна

Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино” гэж заажээ.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2010-2017 оны хичээлийн жилд 113, 2018-2019 оны 94, 2019-2020 онд 95, 2020-2021 онд 88, 2021-2022 онд 88 байсан бол 2022-2023 онд 69 болсон нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд дээд боловсролын сургалтын байгууллагын тоо 26.6 хувиар буурсан бөгөөд дээд боловсрол олгох сургалтын байгууллагын 16 нь төрийн өмчийн, 53 нь төрийн бус өмчийн сургууль эзлэх бөгөөд тэдгээрийн 47.8 хувь их сургууль, 52.2 хувь нь дээд сургуулийн ангилалд хамаарч байна.

Суралцагчдыг боловсролын зэргээр ангилбал, 2021-2022 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 119.3 мянга (80.2 %) нь бакалавр, 25.8 мянга (17.5 %) нь магистр, 3.4 мянга (2.3%) нь докторын түвшний сургалтад сурч байгаа бөгөөд 2010-2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалавр 23.4 хувиар буурч, магистр 2.1 дахин, докторын түвшинд суралцагч 40.2 хувиар тус тус өссөн бөгөөд үндсэн багшийн тоо 2010-2011 оны хичээлийн жилд 7.2 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 7.3 мянга болжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлийг судалж үзэхэд сүүлийн гурван жилд нийт 33.0 мянга орчим оюутан төгссөний 83.0 хувь нь бизнесийн удирдлага, эрх зүйч, барилга угсралт, эрүүл мэнд, нийгмийн халамж, урлагийн чиглэлээр, 17 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, мал эмнэлэг зүй, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр төгсжээ.

Их, дээд сургууль төгсөгчдийг боловсролын зэргээр нь ангилж үзэхэд 2021-2022 оны хичээлийн жилд 0.6 мянга (1.9 хувь) нь дипломын, 26.2 мянга (79.7 хувь) нь бакалаврын, 5.9 мянга (18.1 хувь) нь магистрын, 0.1 мянга (0.3 хувь) нь докторын түвшний сургалтад хамрагдсан байна.

Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журамд заасны дагуу ихэнх их, дээд сургуулиуд ерөнхий байдлаар сургалтын төлөвлөгөөг гаргасан боловч бүрэн хэрэгжүүлээгүй, үнэлгээний үр дүнгээр тасралтгүй сайжруулалтыг хийдэггүй байна.

Зарим их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэхгүйгээр сургалтын хөтөлбөрийг боловсруулснаас дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Тухайлбал:

- Хөтөлбөрийн алсын хараа, хэтийн зорилго, зорилтуудыг тодорхойлсон боловч нэг сургуулийн бүх хөтөлбөрт ижил хуулбарласан;
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Хөтөлбөрийн хороогоор батлуулж, баталгаажуулаагүй, хөтөлбөр боловсруулах, зөвлөмж, заавар байхгүй буюу хөтөлбөр хэрхэн боловсруулах эрх зүйн зохицуулалт бүрдээгүй;
- Тусгай зөвшөөрөл дэх хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлдээгүй, хичээлийн хөтөлбөр боловсруулаагүй;
- Хөтөлбөрийг гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа дутмаг;
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг орчин, ном сурах бичгийн судалгаа хийж тодорхой тусгаадаагүй;
- Сургалтын дадлага хийх байгууллага, бааз дутагдалтай, удирдамжаар бүрэн хангаж ажилладаагүй;
- Ижил төстэй хөтөлбөрүүдийн харилцан зөвшөөрөгдөх бодит нөхцөлийг судалж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсруулах эрх зүйн зохицуулалтагүй.

Энэ нь их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэдэггүй, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарилалт зэрэг асуудалд анхаарлаа хандуулж, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулахгүй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Дээд боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг шинэчилж, зарим сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалсан байна

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар батлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексэд нийцүүлэн дипломын 10, бакалаврын 27, магистрын 10, докторын 11, нийт 58 хөтөлбөрт өөрчлөлт оруулжээ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчилсэн мэргэжлийн чиглэл, индексэд нийцүүлэн шинээр олгох, цахимжуулах ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/197 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, сургалтын үйл ажиллагаа явуулж буй 88 их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн дүгнэлт гаргасан байна.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаагүй үндэслэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шалтгааныг тодруулж үзэхэд зарим их, дээд сургуулиуд холбогдох хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Их, дээд сургуулиас ирүүлсэн үндсэн багшийн тоо, боловсролын зэргийн мэдээлэл нь дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн мэдээлэлтэй зөрүүтэй;
- Тухайн их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүд мэргэжлийн багшгүй эсвэл багшийн тоо шаардлагыг хангахгүй;
- Багш нарын болон төгссөн оюутны диплом олгосон статистик мэдээллийг үнэн бодитой шинэчлэн оруулдаагүй;
- Ерөнхий эрдмийн хичээлийн зарим чиглэлийн багшгүй байгаа нь Дээд боловсролын тухай хуулийн 3.2 дах заалтыг зөрчсөн;
- Нэг багш 2-4 сургуульд үндсэн ба цагийн багшаар ажилладаг;
- Ахисан түвшинд нэг багшид ноогдох оюутан, кредит цагийн ачаалал их, сургалт явуулсан эсэх нь тодорхойгүй;
- Дээд боловсролын тухай хуулийн 8.11 дэх заалтыг зөрчин байгууллагын магадлан итгэмжлэлийг хийлгээгүй;
- Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан байхад сургалтын үйл ажиллагааг явуулсан зэрэг зөрчлүүд байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон их, дээд сургуулийг ижил мэргэжлийн чиглэлийн хөтөлбөртэй их, дээд сургуулиудад нэгдэн орохыг дэмжин ажиллаж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 69 их, дээд сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2019-2021 онд зарим их, дээд сургуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн боловч хяналтаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хангуулах талаар үр дүнтэй ажлыг бүрэн хийгээгүй байна.

Их, дээд сургуулийн багш нарын үр чадварыг хөгжүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2021-2022 оны хичээлийн жилд нийт 12175 ажилтан байгаагаас 50.1 хувь нь үндсэн багш бөгөөд тэдгээрийн 62.0 хувь нь төрийн өмчийн, 35.8 хувь нь хувийн өмчийн, 2.2 хувь нь олон нийтийн буюу шашны дээд сургуульд тус тус ажиллаж байна.

Зарим их, дээд сургуулиуд Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана” гэж заасныг хэрэгжүүлээгүй, төрийн өмчийн 6 их сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд 3227 багш ажиллаж байгаа нь нийт их, дээд сургуульд багшилж буй багшийн 52.9 хувийг эзэлж, тэдгээрийн 22.9 хувь нь дэд профессор, профессор цолтой байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журмын 2.3.2,3.3 заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дээд боловсролын чанар олон улсад өрсөлдөх чадвар сул, докторын зэрэгтэй багшийн нөөц дутагдалтай, зарим их, дээд сургуулиуд үндсэн багшийн эзлэх хувь 30-аас доош, 15 дээд сургуулийн үндсэн багшийн эзлэх хувь 15-аас доош хувьтай, эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь бага, орон тооны докторын зэрэгтэй багшгүй байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал, олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, судалгааны үр дүнг хэлэлцүүлэх, инновац бий болгох зэрэг чадамжийн үнэлгээгээр хангалтгүй дүн гарсан нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 14.1.1-д заасны дагуу багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутам баталж, хэрэгжүүлэхээр байгаа боловч багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын төсөвт тусгуулах ажил хангалтгүй байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт, судалгааны орчин суралцагчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна

“Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5.1-т “Сургалтын зориулалтаар эзэмших барилга байгууламж нь олон нийт иргэний барилгын стандартад заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативыг хангасан байх ба үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээтэй, үүсгэн байгуулагчаас сургуулийн эзэмшилд шилжүүлсэн өөрийн эзэмшлийн сургалтын байртай байна” гэж заажээ.

Монгол Улсад 2022 оны эхний хагас жилийн байдлаар 88 дээд боловсролын сургалтын байгууллага нийт 208 хичээлийн байранд сургалтын үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 196 нь өөрийн, 12 нь түрээсийн байр байгаагаас стандартын шаардлагыг 198 нь хангасан, 10 нь хангаагүй, 19 нь түрээсийн байранд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 7 нь өөрийн эзэмшлийн байртай байна.

Төрийн өмчийн АШУУИС, МУИС, ХААИС, МУБИС, ШУТИС, СУИС зэрэг 6 их сургуулийн болон Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүд зэрэг нийт 124 лаборатори байдаг бөгөөд үүнээс МУИС-16, АШУУИС-15, ХААИС-50, ШУТИС-15, СУИС-1 лабораторитой байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын судалгаа, шинжилгээний лабораториудын эрдэм шинжилгээ, судалгаа, оношилгоо, хяналт, үйлчилгээг сайжруулж, үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага бий болсон байна. Зарим дээд боловсролын сургалтын байгууллага сургалт, судалгааны лабораторигүйгээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байгаа нь дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журмын 2.5.3-т “Сургалт явуулж буй мэргэжлийн лабораторийг стандарт шаардлагын дагуу байгуулж тоноглогсон байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Зарим их, дээд сургуулиуд номын сан, уншлагын танхимгүй сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс 2007 онд баталсан “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлагыг хангасан номын сантай байна. Номын сан нь электрон каталог бүхий мэдээллийн баазтай, цахим хэлбэрээр ашиглах номын фондтой байна” гэж заасантай нийцэхгүй байна.

“Дээд боловсролын сургалтын байгууллагад 2022-2023 оны хичээлийн жилд 17490 оюутны хүчин чадал бүхий 80 дотуур байранд 14282 оюутан амьдарч байгаагаас насжилт өндөр, даац, багтаамж болон нэг оюутанд ногдох нийтийн хэрэглээний өрөө, эд хогшлын нөөц тэдэнд хамаарах стандарт хангагдаагүй, дотуур байрны засвар, үйлчилгээ хангалтгүй, бие даан суралцах танхимын хүрэлцээ дутмаг зэрэг зөрчлүүд байна.

Зарим их дээд сургуулиудын дотуур байр зохих стандарт, аюулгүй байдал хангагдаагүй байгаа тул их, дээд сургуулийн дотуур байрны тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өндөр насжилттай дотуур байруудад мэргэжлийн байгууллагаас дүгнэлтийг гаргуулж, зохих хууль журмын дагуу шийдвэрлэх, стандартын шаардлага хангасан барилга байгууламжтай болоход анхаарах шаардлага бий болсон байна.

Дээд боловсролын сургалт, судалгаанд зориулсан улсын төсвийн дэмжлэг бага байгаа нь салбарын бодлого, хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна

Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааг УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2024 он/, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулиар тус тус зохицуулсан бөгөөд Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээг үйлчилгээний стандарт, чанар, хүрэх үр дүнтэй уялдуулан тогтоох, багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн уян хатан, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан байна.

Улсын төсвөөс дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг баталдаггүй, их, дээд сургуулиуд төсвийнхөө ихэнх хувийг суралцагчаас авах сургалтын төлбөрөөр бүрдүүлдэг бөгөөд улсын төсвөөс сургалт, судалгааны үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн дэмжлэг хангалтгүйгээс багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих нийгмийн баталгаа бүрэн хангагдахгүй, салбарын бодлого, хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг хэд хэдэн эх үүсвэрээс санхүүждэг байхаар хуульчилсан боловч улсын төсвийн санхүүжилт хамгийн бага хувийг эзэлж, нийт орлогын 50.0-85.0 хувийг сургалтын төлбөрөөр бүрдүүлж, бусад эх үүсвэрээс төдийлөн орлого бүрдүүлж чаддаггүйгээс сургалт, судалгааны үйл ажиллагааг санхүүжүүлэх улсын төсвийн дэмжлэг бараг байхгүй байна.

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Дээд боловсролын сургалтын байгууллага санхүүгийн хувьд бие даасан байдлаа хадгалах, сургалт, судалгааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор тодорхой төрлийн дэд сан байгуулах, сангийн хөрөнгөө арвижуулах талаар хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхлэх” гэж заасны дагуу төрийн өмчийн 10 их сургуулиас 3 нь буюу 2019 онд МУИС, ХҮИС Сургууль хөгжүүлэх санг, 2022 онд ХААИС эрсдэлийн санг байгуулсан боловч бусад их сургуулиуд дэд сангүй байна.

Иймд их, дээд сургуулиудын санхүүжилтийг олон талын эх үүсвэрээр бүрдүүлж, төрөөс багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, инновацын үйл ажиллагааг бодлогоор дэмжин салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай байна.

Боловсролын зээлийн сангаар дамжуулан гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцагчдад олгож буй оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, бусад төрлийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл нь дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс олгож буй гол санхүүжилт болж байна.

Боловсролын зээлийн сангаар дамжуулан дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцагч нарт 2019-2022 онд дараах хөнгөлөлттэй зээл, оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгт улсын төсвөөс санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 13186 суралцагчид 11,433.3 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг;
- 22984 суралцагчид 34,780.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, оюутны хөгжлийн зээл;
- Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын (АНУ, Австрали, Англи, БНСУ, Итали, Япон, Тайвань, ХБНГУ, Шинэ Зеланд, Канад зэрэг улсуудад) бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хамрагдсан 211 суралцагчид 16,578.2 сая төгрөгийн зээл;
- Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдсан 407 суралцагчид 32,946.7 сая төгрөгийн зээл;
- Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 390 суралцагчид 13.811.0 сая төгрөгийн гадаад тэтгэлэг.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Боловсролын зээлийн сангийн хөрөнгөөр суралцах суралцагчийг сонгон шалгаруулах, үнэлэх, зээл олгох үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод болгоогүй, нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, цахим хуудаст байршуулах ажил хангалтгүй, эргэн төлөх сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлөх, төлүүлэх асуудлыг журамлаагүй байна. Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д “Гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Боловсролын зээлийн сангаас Засгийн газрын 2014 оны 71, 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-ийг баримтлахгүйгээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад дуурийн гоцлол дуучин, төгөлдөр хуурч, эрх зүйч, загвар зохион бүтээгч зэрэг мэргэжлээр суралцсан суралцагч нарт дараах зээлийг олгосон байна. Тухайлбал:

- Бизнесийн удирдлага, боловсрол судлал, эрүүл мэнд, мэдээллийн технологи, инженерчлэл, хүрээлэн буй орчин, олон улсын харилцаа, загвар зохион бүтээгч, дуурийн гоцлол дуучин, төгөлдөр хуурч, түүхч, нийгмийн антропологи, эрх зүйч мэргэжлээр магистр, докторын хөтөлбөрт хамрагдсан 110 оюутанд 2019 онд 15.6 тэрбум төгрөг, 41 оюутанд 2020 онд 1.7 тэрбум төгрөг, 65 оюутанд 2021 онд онд 3.5 тэрбум төгрөгийн, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 6 оюутанд 0.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй иргэдэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулж, тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр суралцуулахад анхаарч, үндэсний болон гадаадын сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг УИХ

тогтооно” гэж заасныг зөрчин 2009 оноос хойш эргэн төлөх сургалтын төлбөрийн зээлийг Боловсролын салбарын сайд, Боловсролын зээлийн сангийн захирлын тушаалаар тус тус чөлөөлсөн бөгөөд аудитын хамрах хугацаанд буюу 2019-2021 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад доктор, магистр, бакалавраар суралцсан 147 иргэний 8,378.2 сая төгрөгийн зээлийг тус тус чөлөөлжээ.

Энэ нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь заалтыг зөрчсөн байна.

Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.8.9-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн Ажлын алба сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлснээс улсын төсөвт эргэн төлөх зээлийн хэмжээ нь 2019 оны жилийн эцэст 218.8 тэрбум төгрөгийн авлагатай байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 273.5 тэрбум төгрөг болж 54.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцсан иргэдтэй холбоотой зээлийн авлага 101.6 тэрбум төгрөг;
- Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт хамрагдсан суралцагчидтай холбоотой зээлийн авлага 89.6 тэрбум төгрөг;
- Хөнгөлөлттэй зээлийн авлага 15.2 тэрбум төгрөг;
- Оюутны хөгжлийн зээл авлага 67.1 тэрбум төгрөг.

Цаашид дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын улсын төсвөөс олгосон зээлийг хууль, гэрээнд заасны дагуу бүрэн төлүүлэх, Боловсролын зээлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, зээлийн эргэн төлөлт, чөлөөлтийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж байх нь зүйтэй байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний болон магадлан итгэмжлэх зөвлөлийн гишүүдийн хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй байна

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн чадавхыг сайжруулах, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Удирдах зөвлөлийн дарга нь салбарын сайд байна гэж дүрэмд заасан тул тус зөвлөлийн гишүүдийн дотроос даргаа томилдоггүй, үйл ажиллагаагаа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнадаг, ажлын албаны дарга салбарын сайдтай гүйцэтгэлийн гэрээ байгуулдаг зэргээс шалтгаалан Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл хараат бус, бие даан ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

Цаашид Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу хараат бус болгох, удирдлагыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилдог асуудлыг өөрчлөх шаардлагатай байна.

Дээд боловсролын тухай хуульд зааснаар магадлан итгэмжлэл нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хараат бус үнэлгээ хийж, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрч, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргадаг байна.

Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулах байгууллагыг заавал магадлан итгэмжлэх талаар хуульд тусгасан боловч сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх асуудлыг сайн дурын байхаар хуульчилсан нь тухайн хөтөлбөр үнэхээр шаардлагатай эсэх, боловсролын зах зээлд эрэлт хэрэгцээтэй эсэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэгт сөргөөр нөлөөлөхөөр байна.

Их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэл хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахгүй байна

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 2014-2024 оны баримт бичигт мэдлэгт суурилсан ур чадвар бүхий, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх, дээд боловсролын сургалтын байгууллагыг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилтыг тусгасан байна.

Их, дээд сургуулийг 2020-2021 оны хичээлийн жилд 31.2 мянган оюутан төгссөнөөс хууль эрх зүй, боловсрол, бизнесийн удирдахуйн мэргэжлээр хамгийн их буюу 51.6 хувь, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ 15.8 хувь, барилгын инженер, үйлдвэрлэл 13 хувь, сэтгүүл зүй, урлаг 12.6 хувь, мэдээлэл харилцааны технологи, математик, статистик 5.7 хувь, хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн чиглэлийн мэргэжил эзэмшсэн нь 1.3 хувийг тус тус эзэлж байгаа нь Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2021 онд гаргасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанаас харахад 2022 онд эрэлт ихтэй 520 ажил, мэргэжил бүртгэгдсэн бөгөөд үйлдвэрлэл, аж ахуйн, барилгын туслах ажилтан, том оврын ачааны тэрэгний жолооч хамгийн эрэлт ихтэй байжээ. Тухайлбал:

- Цахилгаан инженерийн ажлын байрны эрэлт 600 байгаа бол тус мэргэжлийн дээд боловсрол эзэмшин төгсөж байгаа хүний тоо 541;
- Даатгал, өгөгдлийн шинжээчийн ажлын байрны эрэлт 1945 байгаа бол тус мэргэжлээр дээд боловсрол эзэмшин төгсөж байгаа хүний тоо 167;
- Малын эмч авто машины механик инженер, борлуулалтын ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер, геологич, найруулагч, эвлүүлэгч, хүний их эмч, графикч, дизайнер, зураглаач, төмөрлөгийн хүдрийн инженер, химийн багш, хоол зүйч.мэргэжлээр төгсөгчид дутагдалтай байна.

Боловсролын шинжлэх ухааны яам нь их, дээд сургууль, коллежид мэргэжил эзэмшүүлэхдээ хөдөлмөрийн зах зээлд аль салбарт, ямар мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, эрэлттэй байгаа талаар судалгааг үндэслэн тухайн хичээлийн жилд их, дээд сургуульд ямар чиглэлээр боловсон хүчин бэлтгэх талаар бодлого баримтлахгүй байгаа нь нэг мэргэжлээр хэт олон боловсон хүчин бэлтгэгдэж байгаа нь дээд боловсролтой ажилгүй иргэдийн тоо нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагын удирдлага тогтворгүйгээс олон удаа хуулийн шинэчлэл хийсэн боловч дээд боловсролын хууль, эрх зүйн орчин нийгмийн эрэлт, хэрэгцээг бүрэн хангахгүй байна.
2. Боловсролын тухай хуулиар дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал, хэв шинж, шалгуур үзүүлэлтийг зохицуулаагүйгээс засаглал, удирдлагын бие даасан, хараат бус байдал хангагдаагүй, их, дээд сургуулийн удирдлагыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, чөлөөлөх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.
3. Дээд боловсролын салбарын бодлогын хэрэгжилт, үйл ажиллагаанд тавих Төрийн захиргааны төв болон хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудын хяналт сул, төрийн албаны залгамж чанар алдагдсанаас дээд боловсролын талаар баримтлах урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилт хэрэгжихгүй байна.
4. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт хараат бус үнэлгээ хийж, дүгнэлт гаргах үүрэгтэй Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний болон Магадлан итгэмжлэх зөвлөлийн гишүүдийн хараат бусаар ажиллах нөхцөл бүрдээгүй байна.
5. Сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжлэх асуудлыг хуулиар зохицуулаагүй, их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрийг нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулдаггүй, хуульд заасан чанарын хяналтыг хэрэгжүлдэггүйгээс дээд боловсролын сургалтын чанар сайжраагүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх төгсөгчид бэлтгэгдэхгүй байна.
6. Дээд боловсролын сургалтын байгууллагад докторын зэрэгтэй багшийн нөөц дутагдалтай, үндсэн багш, эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувь бага байгаа нь Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана” гэж заасантай нийцэхгүй байна.
7. Их, дээд сургуулийн хичээлийн байр, лабораториуд сургалт, судалгааны орчныг бүрдүүлээгүй, оюутны дотуур байрууд зохих стандарт, шаардлагад нийцээгүй, зарим сургуулиуд номын сан, уншлагын танхимгүй сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь суралцагчдын нийгмийн баталгааг хангахгүй байна.
8. Гадаадын зээл, тусламжаар дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэх, боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, их дээд сургуулиудын судалгааны лаборатори байгуулах, инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, сургалт, судалгааны тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг төслийг хэрэгжүүлсэн боловч зарим төслийг тооцоо, судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагыг эрэмбэлээгүйгээс хэрэгжилт удааширсан байна.
9. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага сургалт, судалгаанд шаардлагатай дэд санг байгуулах, сангийн эх үүсвэрийг арвижуулах талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх, өргөтгөх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй байгаагаас багш, суралцагчийн нийгмийн баталгааг хангахгүй, төрөөс баримтлах бодлого хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэн байна.
10. Боловсролын зээлийн сангаас суралцагчдад үзүүлэх үндэсний тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгоогүй, улсын төсвөөс дэмжлэг авах суралцагчдын сонгон шалгаруулалт, зээл олголтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангалтгүй, сургалтын төлбөрийн зээлийн чөлөөлөлт, эргэн төлөлтөд тавих хяналт сул байгаагаас жилээс жилд авлагын дүн өссөн байна.
11. Дээд боловсролыг нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах, төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг дэмжих бодлого бүрэн хэрэгжихгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Боловсрол, шинжлэх ухааны сайдад:

1. Нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн дээд боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийг хийх;
2. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал, хэв шинж, шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн оновчтой болгон их сургуулийн удирдлагын хараат бус байдлыг хангаж, албан тушаалыг шалгуурт нийцсэн, мэргэшсэн, мерит зарчмыг баримтлан томилох, эрх үүргийг тодорхой болгох хууль эрх зүйн орчныг бий болгох;
3. Төрөөс дээд боловсролын талаар баримтлах урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, биелэлт, үр дүнг тооцож ажиллах;
4. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний болон Магадлан итгэмжлэх зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хараат бус байдлыг хангах, чанарын баталгаажуулалт, хяналтын тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл хангагдаж байгаа эсэхийг цаг тухайд нь нягтлан шалгах, төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, шалгуурыг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтийг хангуулах;
5. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг тооцоо судалгаанд үндэслэх, их, дээд сургуулийн сургалт, судалгааг дэмжих, тэдгээрийн үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог хөгжүүлэх зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцох боломжийг нэмэгдүүлэх;
6. Их дээд сургуулиудад багш нарт шинэ технологи, сургалтын арга зүйг эзэмшүүлэх, багшийн хөгжил, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, багшийн хөгжлийн хөтөлбөрийг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх;
7. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад зохих стандартын шаардлага хангасан хичээлийн байр, лаборатори, номын сан, нийтийн хоол, биеийн тамирын танхим, оюутны байраар үйлчлүүлэх нөхцөлөөр хангаж, шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх;
8. Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн хэлбэрийг үр ашигтай, оновчтой болгон төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэн эрдэм шинжилгээ, судалгаа инновацын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар орлогын олон талт эх үүсвэрийг бий болгон сургалт, судалгаанд шаардлагатай дэд санг байгуулах, сангийн хөрөнгийг арвижуулах талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь бодлого, хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх;
9. Боловсролын зээлийн сангийн дэмжлэгээр суралцагчдын сонгон шалгаруулалт, зээл олголтын нэгдсэн бүртгэлийг ил тод болгох, зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, зээлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх;
10. Улсын нийгэм, эдийн засгийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан дээд боловсролыг хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх.